



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/196

Мандалговь

“Виктор меп” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Газар усны нэр тодруулах (Гурвансайхан, Сайнцагаан, Говь-Угтаал, Өндөршил, Луус, Дэрэн)” зөвлөх үйлчилгээний багц-1 (Сайнцагаан сум, Луус сум)-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Виктор меп” ХХК-тай 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Газар усны нэр тодруулах (Гурвансайхан, Сайнцагаан, Говь-Угтаал, Өндөршил, Луус, Дэрэн)” зөвлөх үйлчилгээний багц-1 (Сайнцагаан сум, Луус сум) ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Виктор меп” ХХК-ийн захирал (Ш.Наран-Очир)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), Луус сумын Засаг дарга (Г.Баттулга), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060778